



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 12 өдөр

Дугаар A/68

Улаанбаатар хот

### Шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Хотын стандарт, хяналтын газрын дүрмийн 7.1.1, 7.1.2, Хөдөлмөрийн дотоод журмын 8.4.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2023 онд байгууллагын албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлж, эрүүл мэндийг тогтмол дасгалжуулан ажилласан “Биеийн тамир, спорт хамтлаг”-ийн бүрэлдэхүүн, оюун билэг, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд идэвхи оролцоог нэмэгдүүлэн дэмжиж ажилласан “Залуучуудын зөвлөл”-ийн бүрэлдэхүүн, Нийслэлийн Засаг даргын нэрэмжид V бүсийн тэмцээнд 2 дугаар байр эзэлж амжилттай оролцсон “Эмэгтэй гар бөмбөгийн баг”-ийн бүрэлдэхүүн болох нийт 24 албан хаагч тус бүр 80,000 (Наян мянга) төгрөгийн урамшуулал олгосугай.

2.Урамшуулалд зарцуулагдах 1,920,000 (Нэг сая есөн зуун хорин мянга) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас тооцож олгохыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ